

ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНИЙ ТАРХВАР СУДЛАЛ,  
ОНОШИЛГОО, ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН  
АРГА ХЭМЖЭЭ

Ц.ОТГОНЦЭЦЭГ

Тархвар судлагч, тэргүүлэх  
зэргийн эмч

## ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНИЙ ТАРХВАР СУДЛАЛ, ОНОШИЛГОО, ХЯНАЛТ, СЭРГИЙЛЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭ


Тодорхойлолт:

Мэрэгчид, түүний бүүрэг, бөөсөөр дамжин хүн, амьтанд халдварладаг нянгийн гаралтай тунгалагийн зангилаа, уушгийг давамгайлан гэмтээдэг, халууралт, хурц хордлого бүхий байгалийн голомтот халдварт өвчин.

## ТАРВАГАН

## ТАХАЛ

Манай орны 17 аймгийн 130 сумын нутаг тарваган тахлын байгалийн голомттой. Сүүлийн 47 жилд манай орны 13 аймгийн 67 сум, Улаанбаатар хотод 204 хүний өвчлөл бүртгэгдэж, /81/ нас баралт байна..



# Тархвар судлал


## **Эх уурхай:**

Тарваган тахлаар өвчилсөн хүн

Мэрэгч амьтад, түүний сэг зэм

**Шимэгчид** тарваган тахал өвчний дамжуулагч болно.

# Халдвар дамжих зам:



Шууд хавьтлын зам:

Дам халдварын зам:


Агаар дуслын зам:

Хоол хүнсний зам:

# *ТАРВАГАН ТАХЛЫН ЭМНЭЛ ЗҮЙ*


- **Нууц үе:** Хэдэн цагаас 6 хоног, дунджаар 2-3 хоног байна.
- Эмнэлзүйн нийтлэг шинжүүд:
- Өвчин цочмог эхлэх ба дагжин чичирч богино хугацаанд 39-40 хэм хүрч халууран, толгой өвдөх, дотор эвгүйрэх, **нүүр, нүд улайх**, бүх бие, булчин өвдөх шинжүүд илэрнэ.
- Тарваган тахлын эмнэлзүйн хэлбэр:
- Арьсны
- Булчирхайн
- Уушгины
- Үжил
- Гэдэсний
- Залгиур хоолойн

# Тарваган тахлын ӨВЧЛӨЛ



## Булчирхайн хэлбэр:

- Тарваган тахлаар өвчлөгсөдийн 95-98% нь булчирхайн хэлбэрээр өвчилдөг.



# Тарваган тахлын ӨВЧЛӨЛ



## Уушгины хэлбэр:

- Өвчтөнд ерөнхий хордлогын шинжээс гадна, өндөр халуурах, цээжээр хатгуулан өвдөх, цэртэй ханиалгах шинж тэмдэг илэрнэ. Цэр эхэн үед **хөөсөрхөг**, цусны судалтай гарч, дараа нь **цэвэр цусаар ханиана**.
- Цээжний гялтан хальс үрэвссэнээс өвдөлт илэрнэ. Өвчтөн хөөрлийн байдалд орно. Цаашид төв мэдрэлийн тогтолцооны эмгэг өөрчлөлтүүд илэрнэ. Өвчний төгсгөл үед эмнэлзүйн явц хүндэрч халдвар хордлогын шокд орно. Цэрний хамт гадаад орчинд тахлын нян ихээр ялгарна.



# Лабораторийн шинжилгээ

**Шинжилгээнд сорьц цуглуулах** /Өвчтнөөс антибиотик эмчилгээ эхлэхээс эмнө ариун нөхцлийг ханган I зэргийн хамгаалах өмсгөл өмсөж дараах сорьцуудыг авна. Үүнд:

- Булчирхай
- Цэр
- Залгиурын арчдас
- Цус авна.



Дээрхи сорьцуудыг 3 савалгааны зарчмыг баримтлан бүтүүмжилж, мэргэжлийн байгууллагад хүргүүлж шинжлүүлнэ.

# ОНОШИЛГОО

- **Эмнэлзүйн шинж тэмдэг** - **Ялган оношилгоо** (тунгалгийн зангилааны идээт үрэвсэл, бэлгийн замын халдварын үеийн тунгалгийн зангилааны үрэвсэл, боомын арьсны хэлбэр, боомын уушгины хэлбэр, уушгины үрэвсэл, томуугийн хатгалгаа)
- **Тархвар судлалын холбогдол** (тарваган тахлын байгалийн голомтот нутагт амьдардаг эсэх, тарвага, зурам, мэрэгч амьтантай харьцсан /агнасан, арьс, махыг нь авсан, түүхий, шүүрхийгээр нь хэрэглэсэн, бүүрэг, бөөсөнд хазуулсан эсэх, тахлын сэжигтэй, өвчтэй, нас барсан хүнтэй харьцсан эсэх)
  - **Лабораторийн оношилгоо** (Нян харах, нян судлал, ийлдэс судлал, биологи, молекул-биологийн шинжилгээ)

## 12. Тарваган тахал өвчний голомтод авах хариу арга хэмжээ

Алгоритм 1. Анх үзсэн эмчийн авах арга хэмжээ



# Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

## 1. Ард иргэд:

Дархлаажуулалтанд хамрагдах

Тарвага, зурам агнахыг хориглож, түүнтэй харьцахгүй байх

Тарваганы нүх дошны дэргэд сууж амрахгүй байх /тарваганы бүүрэг, бөөсөнд хазуулахгүй байх/

Тарваганы шүүрхий буюу дутуу боловсруулсан мах хэрэглэхгүй байх /эмчилгээний зориулалтаар тарваганы цөс, хүн мах зэргийг хэрэглэхгүй байх/

Үхсэн тарвага, зурамтай тааралдвал уг зүйлд гар хүрэлгүйгээр эмнэлгийн байгууллагад мэдээлэх

Өөрийгөө халдвар авсан гэж үзвэл эмч дуудаж үзүүлэх шаардлагатай

## 2. Эрүүл мэндийн байгууллага:

Эмнэлгийн бэлэн байдлаа хангах, сургалт /танхимийн болон бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу дадлагажих сургалт з/б/